



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/381

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, Байгалийн ургамлын тухай хуулийн 4, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 2, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” 199 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгалийн ургамал түүж бэлтгэх, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Р.Дэжид/-т даалгасугай.

САЙД



Н.БАТЦЭРЭГ

011207

2015 оны

Байгаль орчин, ногоон хөгжил,  
аялал жуулчлалын сайдын  
11 дугаар сарын 10 - ны өдрийн  
10 дугаар тушаалын хавсралт

**Байгалийн ургамал түүж бэлтгэх, тэдгээрийн гаралтай түүхий эд,  
бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгох журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Байгалийн ургамлыг түүж, бэлтгэх, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Байгалийн ургамлыг түүж бэлтгэх, гадаад улсад гаргах зөвшөөрлийг олгохдоо Байгаль орчныг хамгаалах тухай, Байгалийн ургамлын тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг баримтална.
- 1.3. Байгалийн ургамалд ургамал, ургамлын үр жимс, самар, идээ иш мөчир, үндэс, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хамааруулан ойлгоно.
- 1.4. Байгалийн ургамал түүж бэлтгэх, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг аливаа зориулалтаар гадаад улсад гаргах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь уг түүхий эд, ургамлын гарал үүсэл, тоо, хэмжээ, чанар байдал, уг зүйлийг бэлтгэхтэй холбогдсон төлбөр, хураамжийн барагдуулалт, гадаадад гаргах зориулалт, үйл ажиллагаа нь олон улсын холбогдох гэрээ, конвенц, хэлэлцээр, Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг нарийвчлан хянана.

**Хоёр. Байгалийн ургамал түүж бэлтгэх, тэдгээрийн гаралтай түүхий эд,  
бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоход тавих шаардлага**

- 2.1. Байгалийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрлийг Байгалийн ургамлын тухай хуулийн 13-16 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага олгоно.
- 2.2. Байгалийн ургамал түүж бэлтгэх, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаадад гаргах зөвшөөрөл хүсэж буй иргэн, хуулийн этгээд нь байгалийн ургамал түүж бэлтгэх, байгалийн нөөц ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамж төлөхтэй холбогдсон зөрчилгүй байна.
- 2.3. Гадаад улсад гаргах байгалийн ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг Байгалийн ургамлын тухай хуулийн 13-16 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн дагуу бэлтгэсэн байна.
- 2.4. Нэн ховор, ховор ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийг судалгаа, шинжилгээний зориулалтаар эсвэл эцсийн бүтээгдэхүүн болсон тохиолдолд гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоно. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа олгосон өдрөөс хойш хуанлийн 30 хоног байна.
- 2.5. Байгалийн ургамал түүж бэлтгэх, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргах зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдийн эрх бүхий байгууллагад гаргасан хүсэлтийг үндэслэн олгоно.

2.6. Байгалийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ дараах баримтыг үндэслэнэ. Үүнд:

2.6.1. иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.6.2. түүж бэлтгэх ургамлын нэр, зориулалт, хэмжээ;

2.6.3. үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж, бэлтгэх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ;

2.7. Эрх бүхий байгууллагаас байгалийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл олгосны дараа сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулан, байгалийн нөөц ашигласны төлбөрийг холбогдох дансанд тушаана.

2.8. Байгалийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрөлд ургамал түүж бэлтгэх газрын нэр, хугацаа, хэмжээг тодорхой заана.

2.9. Байгалийн ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ дараах баримтыг үндэслэнэ. Үүнд:

2.9.1. иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.9.2. эрх бүхий байгууллагаас олгосон байгалийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрлийн эх хувь;

2.9.3. байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр төлсөн тухай баримт;

2.9.4. гадаад худалдааны гэрээ /монгол хэл дээр/;

2.10. Байгалийн ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авсан бол энэ журмын 2.9-д заасан бичиг баримтыг мөн адил шаардана.

2.11. Судалгаа шинжилгээний зориулалтаар байгалийн ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаадад гаргах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ энэ журмын 2.9.1, 2.9.2, 2.9.3-т заасан бичиг баримтаас гадна сорьц дээж авах, гадаадад гаргах тухай гадаад, дотоодын байгууллагатай хийсэн гэрээ, хэлцлийг үндэслэнэ.

2.12. Материалыг хянан үзэж, байгалийн ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгох тухай шийдвэр гарсны дараа хүсэлт гаргагч нь улсын тэмдэгтийн хураамжийг холбогдох дансанд тушаасан баримтыг ирүүлнэ.

2.13. Ирүүлсэн баримтад үндэслэн байгалийн ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаадад гаргах зөвшөөрлийг олгоно.

### **Гурав. Бусад**

3.1. Хүсэлт гаргагчийн ирүүлсэн материалыг хянан үзэж зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгохгүй байх үндэслэл, тайлбараа албан бичгээр хүргүүлнэ.

3.2. Зөвшөөрөл хүсэхдээ дутуу, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, хууль бусаар түүж, бэлтгэсэн үйлдэл нь тухайн иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгохгүй байх үндэслэл болно.

3.3. Зөвшөөрөлд заасан хэмжээгээр байгалийн ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргаж чадаагүй улмаас дахин зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэхдээ анх авсан зөвшөөрөл дээр хийсэн гаалийн байгууллагын тэмдэглэгээг үндэслэнэ.

3.4. Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, гаалийн удирдах төв байгууллагын лавлагаа, давагдашгүй хүчин зүйлийн шалтгааныг нягтлан үзсэний үндсэн дээр зөвшөөрөл олгосон албан тушаалтан зөвшөөрлийн хугацааг хуанлийн 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам